

3

Нийлүүлэгчийн Гэрээ Хэрэгжүүлэх Чадварын Тухай

УДИРТГАЛ 40

- | | | |
|----|--------------------------------|----|
| 1. | Бодлогын баримт бичгийн дугаар | 40 |
| 2. | Зорилго | 40 |
| 3. | Хамрах хүрээ | 41 |
| 4. | Мөрдөж эхлэх хугацаа | 41 |
| 5. | Бүрэн эрх, удирдлага | 41 |

БОДЛОГО 42

1. Оюу Толгой ХХК-ийн Нийлүүлэгчийн Гэрээ Хэрэгжүүлэх Чадварын Тухай Бодлого 42

1.1 Оюу Толгой ХХК-д үйлчилгээ үзүүлж буй голлох нийлүүлэгчдийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нягтлах.

1.2 Ирээдүйд Оюу Толгой ХХК-д үйлчилгээ үзүүлэх нийлүүлэгчид урьдчилан сонголтод тэнцэн, цаашид өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад оролцох боломжтой эсэхийг нягтлах.

2. Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаанд нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх үйл явцын гүйцэтгэх үүрэг 45

Удиртгал

1. Бодлогын баримт бичгийн дугаар

Энэхүү баримт бичгийг ХААБ-02: **Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын тухай бодлого** хэмээн нэрлэнэ.

2. Зорилго

Оюу Толгой ХХК (ОТ) нь уурхайн буюу нөөц баялгийн салбарын шаардлагуудыг хангах, гэрээ хэрэгжүүлэх чадвар бүхий нийлүүлэгчидтэй хамтран ажиллах боломжийг бүрдүүлэхийн тулд энэхүү бодлогыг боловсруулсан бөгөөд дор дурдсан шаардлагыг (мөн эдгээрээр хязгаарлагдахгүй) тавина . Үүнд:

- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин (ЭМААБО)-ны
- Санхүүгийн
- Ёсзүйн болон дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг хөгжүүлэх
- Чанарын удирдлагын
- Хууль эрх зүйн ба мэдээллийн аюулгүй байдлын
- Хүний нөөцийн удирдлагын
- Үйлчилгээ ба лавлагааны шаардлагууд болно.

Нэгдүгээр зурагт харуулснаар , “ХААБ 02: Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын тухай бодлого ” нь Оюу Толгой ХХК-ийн худалдан авах үйл ажиллагаанд баримтлах үндсэн найман бодлогын нэг юм.

Зураг 1: Оюу Толгой ХХК-ийн худалдан авах үйл ажиллагааг удирдан зохицуулах үндсэн бодлогын баримт бичгүүд



3. Хамрах хүрээ

Тус бодлогын баримт бичгийг дараах хүмүүс даган мөрдөнө:

- Оюу Толгой ХХК-ийн бүх ажилтнууд;
- Цаашид Оюу Толгой ХХК-ний өрсөлдөөнт тендерт оролцох хүсэлтэй бүх үйлчилгээ үзүүлэгчид (ажлын талбайд байрлаж ажиллах бүрэлдэхүүн хэсэг бүхий)
- Оюу Толгой ХХК-д одоогоор үйлчилгээ үзүүлж буй нийлүүлэгчид

Өнөөгийн байдлаар гэрээ хэрэгжүүлэх чадвартай байх шаардлагатай олон тооны нийлүүлэгчид Оюу Толгой төслийн талбайд ажиллаж байна. Иймд эхний ээлжийн зорилтот нийлүүлэгчдийг тодорхойлохын тулд аливаа эрсдлийг тооцсон, төслийн удирдлагын тэргүүлэх чиглэлээ урьдчилан тогтоох шаардлага урган гарч байна. Ажлын талбайд үйлчилгээ үзүүлж буй өндөр эрсдэл бүхий нийлүүлэгчдийг 2012 оны 8 дугаар сар гэхэд “нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын үндсэн шалгуурыг хангасан байдал”-д хүргэх зорилгоор тус хөтөлбөрийг боловсруулав.

4. Мөрдөж эхлэх хугацаа

Энэхүү шинэчлэн найруулсан бодлогыг 2012 оны 11-р сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

5. Бүрэн эрх, удирдлага

Энэхүү шинэчлэн найруулсан бодлогын баримт бичгийг Оюу Толгой ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2012 оны 11-р сарын 20-ны өдөр батлав.

Энэхүү баримт бичгийг жил бүр эсхүл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хянан засварлана.

Оюу Толгой ХХК-ийн Хангамж, дэд бүтцийн хөгжил хариуцсан Дэд ерөнхийлөгч нь тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хариуцна. Энэхүү бодлогод өөрчлөлт оруулах аливаа санал хүсэлтийг дээрх албан тушаалтанд гаргах бөгөөд тэрээр зохих ёсоор хянан, батална.

Бодлого

1. Оюу Толгой ХХК-ийн Нийлүүлэгчийн Гэрээ Хэрэгжүүлэх Чадварын Тухай Бодлого

Оюу Толгой ХХК-ийн нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын талаар баримтлах энэхүү бодлого нь Рио Тинто-гийн олон улсын загварт тулгуурласан, нийлүүлэгчийн чадавхийг дор дурьдсан долоон шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэн, алдаа дутагдалтай талуудыг нь илрүүлэх зорилгоор боловсруулагдсан болно. Эдгээр нь:

- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин (ЭМААБО)-ны
- Санхүүгийн
- Ёсзүй болон дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг хөгжүүлэх
- Чанарын удирдлагын
- Хууль эрхзүйн ба мэдээллийн аюулгүй байдлын
- Хүний нөөцийн удирдлагын
- Үйлчилгээ ба лавлагааны шаардлагууд зэрэг болно.

Оюу Толгой ХХК-ийн Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын талаар баримтлах бодлогыг Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 14-16 дугаар зүйлүүдэд заасан шаардлагуудтай нийцүүлэн боловсруулсан болно. Үүнээс гадна энэхүү бодлого нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд үлэмж анхаарал хандуулдаг уул уурхайн салбарын онцлог шаардлагуудыг мөн өөртөө агуулсан болно.

Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжээс дотоодын нийлүүлэгчидтэй ажиллаж, урьдчилсан сонголт болон үндсэн шалгуур үзүүлэлтээр нь үнэлэх явцад тэдэнтэй ажиллаж дэмжих тусгай ажлын хэсэг буюу “Дотоодын нийлүүлэгчдийг хөгжүүлэх баг” (инженер техникийн болон арилжааны туслах ажилтнуудаас бүрдэх) –ийг ажиллуулна. Энэхүү баг нь ажил хэргээ англи монгол хэл дээр явуулах чадвартай, дотоодын нийлүүлэгчдийн оролцоог нэмэгдүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг даван туулах талаар ихээхэн туршлага хуримтлуулсан мэргэжилтнүүдээс бүрдэх юм. Оюу Толгой ХХК-ийн нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын талаар баримтлах бодлого нь бүх худалдан авалтын нэр төрлүүдэд үйлчилгээ үзүүлж буй болон цаашид үйлчилгээ үзүүлэх хандлагатай нийлүүлэгчдийн хэн алинд ялгалгүй хамаарах бөгөөд Оюу Толгой төслийн ажлын талбай дээр үйлчилгээ үзүүлж буй болон цаашид үзүүлэх нийлүүлэгчдийг нэн тэргүүний ач холбогдолт байдлаар нь эрэмбэлэхэд чиглэгдсэн болно.

Оюу Толгой ХХК нь холбогдох үйлчилгээний худалдан авалтын ангиллыг ХААБ 01: Хөрөнгө зарцуулалтыг төрөлжүүлэх, ангилах тухай бодлого”-д тодорхойлсон зарчмуудын дагуу тухайн үйлчилгээний нэр төрлийн нарийн

төвөгтэй ба үйл ажиллагаанд нөлөөлөх байдлыг харгалзан уялдуулж тодорхойлно.


Түүнчлэн өрсөлдөөнт шалгаруулалтад оролцох хүсэлтэй буюу Оюу Толгой ХХК-д үйлчилгээ үзүүлэх сонирхолтой нийлүүлэгчид энэхүү гэрээ хэрэгжүүлэх чадварын шаардлагыг хангасан байна. Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх үйл явц нь Оюу Толгой ХХК-ийн худалдан авалтын төрөл, үйлчилгээний ерөнхий нарийн төвөгтэй байдал, Оюу Толгой төслийн талбай дахь үйл ажиллагаанд хэр нөлөөлөх зэрэг байдлаас хамаарна.

Өмнөговийн нийлүүлэгчийн давуу эрх эдлэх ангилалд хамаарах болон цаашдын өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад оролцон гэрээ хэрэгжүүлэх өндөр чадавхи бүхий Нийлүүлэгчдийг үнэлэх ажил нь Оюу Толгой ХХК-ийн нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын талаар баримтлах бодлогын хүрээнд мөн тэргүүлэх ач холбогдолтой байна.

Чадавхийг үнэлэх үйл явц нь урьдчилсан сонголт болон үндсэн шалгуур үзүүлэлтээр үнэлэх гэсэн хоёр үе шатаас бүрдэх бөгөөд энэ нь бүх оролцогчдийг /нийлүүлэгчдийг/ долоон төрөлд ангилагдсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлэх зорилготой юм. Ингэснээр нийлүүлэгчдийн гэрээ хэрэгжүүлэх чадварт шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн хангаж буй эсэхэд оноо өгч үнэлнэ.

- Урьдчилсан шалгуур үзүүлэлтээр үнэлэх шат нь бүх нийлүүлэгчдийг Оюу Толгой ХХК-ийн урьдчилсан сонголтын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх эхний шат юм. Энэхүү эхний үнэлгээний шат нь ЭМААБО-ны гол шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурласан бөгөөд Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 14-16 дугаар зүйлүүдэд заасан үндсэн шаардлагуудыг тусгасан болно.
- Урьдчилсан сонголтын шатыг амжилттай давсан нийлүүлэгчид нь өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын талаарх зарыг хүлээн авах боломжтой болох бөгөөд үндсэн шаардлагын шалгуур үзүүлэлтээр үнэлэх шат руу шилжинэ.

Дотоодын нийлүүлэгчдийн хангах босго оноог тэдгээрийн олонхийн хувьд буй хөгжлийн түвшинд буюу хөгжиж буй статуст нь тааруулан тогтоож, гэрээ хэрэгжүүлэх чадавхи болон гүйцэтгэлийн дутагдалтай байдлыг шийдэх зорилгоор нийлүүлэгчийг хөгжүүлэх, чадавхийг сайжруулах төлөвлөгөөг гаргасан болно. Дотоодын нийлүүлэгчийг хөгжүүлэх энэхүү тусгайлан төлөвлөгөөний загварыг “Зураг-2”-с харна уу. Дутагдалтай тал, байдал илэрсэн тохиолдолд, Оюу Толгой ХХК нь уг дутагдлын хэмжээг харгалзан тухайн нийлүүлэгчид Оюу Толгой төслийн талбайд ажиллахаас нь эсхүл сонгон шалгаруулалтанд оролцохоос өмнө тодорхой хугацаанд дутагдлаа залруулах арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлно.



Цаашид үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж байх байгууллагын соёл, дадал зуршлыг тогтоохын тулд ажлын гүйцэтгэлд нь байнгын хяналт тавих, тэдний гаргасан амжилтын түвшинг тогтоох зорилгоор нийлүүлэгчдийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг жил тутамд дахин үнэлнэ. Ийнхүү чадавхиа дахин үнэлүүлснээр нийлүүлэгчдийн хувьд Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах үйл ажиллагааны үүрэг хариуцлага, шаардлагуудыг хангах, хамтран ажиллах боломж бүрдэнэ. Түүнчлэн дотоодын нийлүүлэгч нарт Оюу Толгой төслийн хэрэгжилтийн явцад өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад амжилттай оролцох техникийн болон бизнесийн туршлага, ур чадвараа хөгжүүлэх боломж олгоно.

Нийлүүлэгчдийг хөгжүүлэх үйл ажиллагааны талаар нэмэлт мэдээллийг “ХААБ 06: Өмнөговийн нийлүүлэгчийг хөгжүүлэх бодлого” болон “ХААБ 07: Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх бодлого”-оос үзнэ үү.

Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын талаар баримтлах бодлогын хүрээнд чадавхиа үнэлүүлснээр дотоодын нийлүүлэгчид Монгол улсад хөгжиж буй уул уурхайн үйлдвэрлэл/нөөц баялгийн салбарт тавигдах үүрэг хариуцлага, шаардлагуудыг хангах үнэтэй мэдлэг туршлага хуримтлуулах болно. Дэлхийн хэмжээний ЭМААБО-ны болон чанарын баталгааны шаардлагыг хангах мэдлэг туршлагыг хуримтлуулснаар дотоодын ханган нийлүүлэлтийн бааз суурь нь цаашдаа урт хугацааны бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадвартай болно. Дотоодын нийлүүлэгч нь Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын талаар баримтлах бодлогын шаардлагыг биелүүлснээр шилдэг стандарт/жишиг/, шаардлага хангасан байх чадвартаа итгэлтэй болох бөгөөд энэ нь тэдэнд цаашид бизнесээ өргөжүүлэх, шинэ талбарт нэвтрэх боломжийг олгоно.

1.1. Оюу Толгой ХХК-д үйлчилгээ үзүүлж буй голлох нийлүүлэгчдийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нягтлах.

Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нягтлах ажиллагааны хүрээнд эхний ээлжинд Оюу Толгой ХХК-д үйлчилгээ үзүүлж буй бүх нийлүүлэгчдийг эрэмбэлэн урьдчилсан сонголтын болон үндсэн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Мөн Оюу Толгой төслийн ажлын талбайд гэрээний дагуу худалдан авалтын холбогдох нэр төрөлд хамаарах үйлчилгээ үзүүлж буй нийлүүлэгчдийг урьдчилсан сонголтын болон үндсэн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Эдгээр нийлүүлэгчдийн ажлын талбай дахь гүйцэтгэл, идэвх чармайлт нь Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагаанд нөлөөлж буй болон худалдан авах үйл ажиллагааны шаардлагын дагуу, ялангуяа ЭМААБО-ны шаардлагад нийцэж буй байдалд нь эхний ээлжинд ач холбогдол өгч, нягтлан үнэлнэ.

1.2. Ирээдүйд Оюу Толгой ХХК-д үйлчилгээ үзүүлэх нийлүүлэгчид урьдчилан сонголтод тэнцэн, цаашид өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад оролцох боломжтой эсэхийг нягтлах.

Оюу Толгой ХХК-ийн төслийн талбайд ажиллаж буй нийлүүлэгчдийн урьдчилсан сонголтын дараагаар цаашид тэдгээр нийлүүлэгчдийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг Оюу Толгой ХХК-аас тухайн үйлчилгээний худалдан авалтын төрөлд хамааран тавих үндсэн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх бөгөөд эдгээр шаардлага нь нийлүүлэгчдийн дунд хойшид зарлагдах сонгон шалгаруулалтын хувьд тухайн нийлүүлэгчийг гэрээ хэрэгжүүлэх чадвартай гэж үзэх үндэслэл юм.

Үндсэн шалгуурыг хангасан нийлүүлэгчийн мэдээллийг Оюу Толгой ХХК-ний нийлүүлэгчийн мэдээллийн санд оруулан, “Нийлүүлэгчийн үндсэн шалгуурыг хангасан” гэсэн тэмдэглэгээ хийн бүртгэн авах бөгөөд энэ нь тухайн нийлүүлэгчийн салбарт хамаарах үйлчилгээний нэр төрлийн тендер шалгаруулалтад оролцох боломжтой, чадвартай гэдгийг илэрхийлнэ.

2.

Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаанд нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх үйл явцын гүйцэтгэх үүрэг

Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын талаар баримтлах бодлогын үүрэг нь Оюу Толгой ХХК-ийн ЭМААБО-ны болон бусад бизнесийн зарчмыг бидний нэгэн адил баримталдаг шаардлага хангасан нийлүүлэгчидтэй хамтран ажиллах тухай зарчмуудад үндэслэсэн болно.

Зураг 3-т “Нийлүүлэгчийн Гэрээ хэрэгжүүлэх чадварын үнэлгээний тайлан”-гийн загварыг харуулсан ба үүнд Оюу Толгой ХХК-ийн нийлүүлэгчдэд тавих шалгуур үзүүлэлтүүдэд хамаарах ханган нийлүүлэгчийн гүйцэтгэл буюу шаардлага хангасан байдлыг тусгасан болно.

Зарим онцгой худалдан авалтын төрлүүдэд (тухайлбал үйлдвэрлэлийн

хэрэгцээт зүйлс, зэс баяжуулах үйлдвэр зэрэг), нийлүүлэх бүтээгдэхүүний техникийн шинж байдлаас хамааран тусгай шаардлага бүхий үзүүлэлтийг нэмэлтээр боловсруулан шалгуур үзүүлэлтэнд тусгайлан оруулж болно. Үүнийг үл харгалзан, Оюу Толгой ХХК нь нийлүүлэгчийн чадавхийг худалдан авалтын ямар төрөлд үнэлсэн болохыг харуулсан “Гэрээ хэрэгжүүлэх чадварын шаардлагыг хангасан Нийлүүлэгчийн мэдээллийн сан”-г (Нийлүүлэгчийн нэгдсэн жагсаалт -НЖЖ) бүрдүүлнэ. Эдгээр нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтыг Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн цахим хуудас /вэбсайтын портал/ дээр байршуулна. Өөр бусад худалдан авалтын нэр төрлүүдийн өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй, тухайн худалдан авалтын төрлөөр үндсэн шалгуурыг нь хангасан хэмээн тэмдэглэгээ хийгдээгүй бол, уг өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад оролцох зөвшөөрөл олгохоос өмнө тухайн нийлүүлэгч нь дахин үнэлгээнд хамрагдах тухайн бараа, үйлчилгээний худалдан авалтын төрөлд чадвартай гэдгээ нотлон харуулсан байна .

Нийлүүлэгчийн Гэрээ Хэрэгжүүлэх Чадварын Үнэлгээний

БИЗНЕСИЙН НЭГЖ/ҮҮРЭГ

ХАНГАЛТ НИЙЛҮҮЛЭГЧ КОМПАНИЙН НЭР

МЭРЭГ

МЭРЭГ

ШАЛГАЛТ/АУДИТ ХИЙСЭН ӨГНӨО

ОЛТИ ҮНДЭСН АНГИЙЛЫН САЛБАР

МЭРЭГ

МЭРЭГ

| САЛБАР | ЭЗЛЭХ ЖИЛ | | | SCORE | |
|-----------------------------------|---------------|---------------|--------------|-------------|----------------|
| | ЭХНИЙ ШАЛГУУР | УРЬДАЛ ШАЛГАР | ДАХИН ШАЛГАР | ӨМНӨХ ХЭСЭГ | ОДООГИЙН ХЭСЭГ |
| ЗМААБОО | 55.0% | 40.0% | 40.0% | 0.00 | 4.36 |
| САВХУУ | 0.0% | 15.0% | 15.0% | 0.00 | 4.14 |
| БЭ ЗҮЙЛ ОЛОН НИЙЛЭГЧ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | 10.0% | 10.0% | 10.0% | 0.00 | 3.30 |
| НАМАЙН МЕНЕЖМЕНТ БА ХЭЗЭГ | 0.0% | 10.0% | 10.0% | 0.00 | 0.00 |
| ҮЙЛЧИЛГЭЭ, НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ | 0.0% | 0.0% | 0.0% | 0.00 | 0.00 |
| Х.ЭРХ, М.АЛСНИЙ А.ГУЙ БАЙДАЛ | 10.0% | 7.5% | 7.5% | 0.00 | 3.03 |
| УН МЕНЕЖМЕНТ | 20.0% | 12.5% | 12.5% | 0.00 | 3.00 |
| НИЙТ | 100% | 100% | 100% | 0.00 | 3.71 |

НАДАВИБОЛОН КУЧИНИЙГ ХУГАЦААНЫ ШИЙДЭГ

ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ШИЙДЭГ

Pre-Qualified, ready to transact immediately with minimum supervision.

Pre-Qualified avec supervision minimale

ҮНЭЛГЭЭНИЙ ХЭМНЭГЭЙ ХУГАЦАА

36 MONTHS

ДҮНДЭЛТ

ӨРНӨХИЙ АЖИЛАЛТ

Оюу #1

Оюу #2

ДАВУУТАЙ ЗҮЙЛС

Гэрээ хэрэгжүүлэх чадварын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэгч нь өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй болж, Оюу Толгой ХХК-ийн нийлүүлэгчийн мэдээллийн санд “Гэрээ хэрэгжүүлэх чадвартай, сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй” гэж бүртгэгдэнэ. “Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын шалгуурыг хангасан” байдал нь Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаанд баримтлах бодлогын дагуу тухайн төрлийн худалдан авалтын сонгон шалгаруулалтад оролцох, сонгон шалгаруулалтад тавигдах үнэлгээний стандарт /жишиг /шалгуурыг хангасан байх шаардлагаас нийлүүлэгчийг чөлөөлөх үндэслэл болохгүй.